



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 07 дугаар сарын 25  
№29 (1374)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ  
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

142.	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1193
143.	Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай		1207
144.	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1208
145.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1209
146.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1227
147.	Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1228

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

148.	Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 57	1229
149.	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 61	1237
150.	Хянан шалгах түр хороо байгуулах тухай	Дугаар 62	1243



151.	Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	Дугаар 63	1247
152.	Тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 64	1249
153.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 65	1251
154.	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 67	1253







## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт:**

“4.1.1.хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх;”

#### **2/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг:**

“12.4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй.”

#### **3/15 дугаар зүйлийн 15.13 дахь хэсэг:**

“15.13.Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалд баталсан он, сар, өдрийг тусгана.”

#### **4/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:**

“17.3.Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-т заасан үнэлгээнд нэмж тусгана:

17.3.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;

17.3.2.ялгаварлан гадуурхаагүй байх;

17.3.3.хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.”

#### **5/18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг:**

“18.3.Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газар, эсхүл хууль зүйн, төсвийн судалгааны чиглэлийн хүн, хуулийн этгээд энэ хуулийн 18.1-д заасан зардлын тооцоог хийнэ.”

**6/27<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“27<sup>1</sup> дүгээр зүйл.Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад тавих шаардлага**

27<sup>1</sup>.1.Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад дараах шаардлагыг хангасан байна:

27<sup>1</sup>.1.1.хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

27<sup>1</sup>.1.2.тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх;

27<sup>1</sup>.1.3.захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх;

27<sup>1</sup>.1.4.зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх;

27<sup>1</sup>.1.5.захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх;

27<sup>1</sup>.1.6.хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх.

27<sup>1</sup>.2.Дараах асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй:

27<sup>1</sup>.2.1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах, хариуцлага оногдуулах;

27<sup>1</sup>.2.2.Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа;

27<sup>1</sup>.2.3.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа;

27<sup>1</sup>.2.4.гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүрэг.

Тайлбар: гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүргийг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд бусад асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар тогтоож болно.



27<sup>1</sup>.3.Захиргааны хэм хэмжээний акт гаргах хугацааг энэ хуулийн 27.1-д заасан хуулийг дагаж мөрдөх журамд тусгана.”

**7/28 дугаар зүйлийн 28.3.6 дахь заалт:**

“28.3.6.асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа явуулах журам, бүрэн эрх;”

**8/29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг:**

“29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана.”

**9/33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалт:**

“33.3.3.хуулийн төсөлтэй холбогдуулан гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтад харьцуулалт хийж, тусгасан тохиолдолд тэдгээрийн талаарх тайлбар, дүгнэлт;”

**10/38 дугаар зүйлийн 38.10 дахь хэсэг:**

“38.10.Хууль санаачлагч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөс энэ хуулийн 38.6.1, 38.6.2-т заасан хэлбэрээр санал авч, хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.”

**11/39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг:**

“39.3.Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссоос, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос тус тус санал авах бөгөөд ажлын 30 өдрийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.”

**12/40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалт:**

“40.1.3.хууль тогтоомжийн төслийн энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан товч болон дэлгэрэнгүй танилцуулга;”



**13/40 дүгээр зүйлийн 40.1.12, 40.1.13 дахь заалт:**

“40.1.12.энэ хуулийн 13.2.6-д заасан судалгааны тайлан;  
40.1.13.энэ хуулийн 27<sup>1</sup>.1-д заасны дагуу батлах захиргааны хэм хэмжээний актын жагсаалт, 27<sup>1</sup>.3-т заасан хугацааны талаарх мэдээлэл.”

**14/41 дүгээр зүйлийн 41.3.6 дахь заалт:**

“41.3.6.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.15-д заасан хугацааг хангасан эсэх.”

**15/44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг:**

“44.3.Холбогдох төрийн байгууллага нь хүний хувийн мэдээлэл, төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад хууль тогтоомжийн хувийн хэрэгтэй иргэд, олон нийт чөлөөтэй танилцах нөхцөлийг бүрдүүлнэ.”

**16/45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг:**

“45.5.Хууль тогтоомжийн цахим сан нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон хэлбэрээр ашиглах боломжтой байна.”

**17/51 дүгээр зүйлийн 51.5 дахь хэсэг:**

“51.5.Энэ хуулийн 49.1, 49.2-т заасан этгээд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.”

**2 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “үр нөлөөг” гэсний дараа “шалгуур үзүүлэлтийг сонгох, хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг сонгох, үр нөлөөг тооцох, үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шаттайгаар” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.1 дэх заалтын “нийцэж байгаа эсэх” гэсний дараа “, түүний үзэл баримтлалыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг дэмжиж байгаа эсэх үндэслэл, тайлбар” гэж, мөн зүйлийн 21.13 дахь хэсгийн “бодлогод нийцээгүй,” гэсний дараа “тухайн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг бүхэлд нь дэмжих боломжгүй,” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 28.3.1 дэх заалтын “гарчиг” гэсний дараа “, бүтцийн товьёг” гэж, 28.3.3 дахь заалтын “нэр томьёоны тайлбар” гэсний өмнө “цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулсан” гэж, 33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалтын “ухагдахууны үүсэл” гэсний дараа “, нэр томьёог нийцүүлсэн талаарх тайлбар” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэсний өмнө “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж” гэж, 38 дугаар зүйлийн 38.2



дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэсний дараа “болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд” гэж, 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсгийн “байршуулах бөгөөд” гэсний дараа “хууль тогтоомжийн “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн эх хувь, түүний үзэл баримтлал, хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийн түүх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хавсаргана. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/13 дугаар зүйлийн 13.2.6 дахь заалт:**

“13.2.6.шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, хөгжлийн чиг хандлагыг харгалзан оновчтой хувилбарыг үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан хийх.”

**2/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:**

“17.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн судлаач, хуулийн этгээдээр энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу гүйцэтгүүлнэ.”

**3/18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг:**

“18.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу дараах байдлаар үнэлж, тодорхойлно:

18.1.1.хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох;

18.1.2.хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцох.”

**4/38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсэг:**

“38.7.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх саналын товъёгийг тайлбар, үндэслэлийн хамт албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах



нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна.”

#### **5/40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэг:**

“40.3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115, 117, 118 дугаар зүйлд заасан тайлан, илтгэл энэ хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна.”

#### **6/49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дахь хэсэг:**

“49.1.Дараах хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох байгууллага хэрэгжүүлнэ:

49.1.1.Улсын Их Хурлын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг зохицуулж байгаа хууль тогтоомж;

49.1.2.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг зохицуулж байгаа хууль тогтоомж.

49.2.Энэ хуулийн 49.1, 49.3-т зааснаас бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.”

**4 дүгээр зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.4-т” гэж, 38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж, мөн зүйлийн 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “39.3-т” гэснийг “39.3, 39.4-т” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.9 дэх заалтын “40.1.1-40.1.8-д” гэснийг “40.1.1-40.1.9-д” гэж, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн “хянана” гэснийг “хянах бөгөөд төслийн бүрдүүлбэрийг хянах хуудсыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална” гэж, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “гэрээний” гэснийг “гэрээ, түүний хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулга, эх бичвэрийн” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.4 дэх заалтын дугаарыг “4.1.2-4.1.5” гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн дугаарыг “17.4” гэж, 28 дугаар зүйлийн 28.3.6-28.3.10 дахь заалтын дугаарыг “28.3.7-28.3.11” гэж, 33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалтын дугаарыг “33.3.4” гэж, 39 дүгээр зүйлийн 39.3, 39.4 дэх хэсгийн дугаарыг “39.4, 39.5” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтын дугаарыг “40.1.4” гэж, мөн зүйлийн 40.1.4 дэх заалтын дугаарыг



“40.1.6” гэж, мөн зүйлийн 40.1.6-40.1.10 дахь заалтын дугаарыг “40.1.7-40.1.11” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн дугаарыг “44.4” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсгийн “12.2.1,” “12.2.17,” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “товч болон дэлгэрэнгүй танилцуулга,” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**



МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН ХУУЛЬ

















**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтын “хуульд нийцсэн” гэсний дараа “, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаагүй, иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**

Хуульчилсан үсэг

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠ  
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠨᠢᠨᠢᠭ᠋ᠣᠨ ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ  
ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠ  
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠨᠢᠨᠢᠭ᠋ᠣᠨ ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ  
ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠠ  
ᠲᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠨᠢᠨᠢᠭ᠋ᠣᠨ ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ  
ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ  
ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠲᠤᠰᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
ХОТ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“36.1.2.Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний тодотгол, гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмч, татвар, эрүү, иргэн болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль тогтоомжийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах.”

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Хуульчилсан үсэг

᠒᠐25 оны ᠐᠖ сарын 27-ны өдөр /᠒᠐25 оны ᠐᠖ сарын 27-ны өдөр

Хуульчилсан үсэг /᠒᠐25 оны ᠐᠖ сарын 27-ны өдөр

᠑. 36.1.2. Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний тодотгол, гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмч, татвар, эрүү, иргэн болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль тогтоомжийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах.”

᠒. 36.1.2. Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний тодотгол, гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмч, татвар, эрүү, иргэн болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль тогтоомжийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах.”

Хуульчилсан үсэг /᠒᠐25 оны ᠐᠖ сарын 27-ны өдөр

᠒᠐25 оны ᠐᠖ сарын 27-ны өдөр

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 06 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/5.1 дүгээр зүйлийн 2.7 дахь заалт:**

“2.7.энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хуулбарлан авах зорилгоор зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах;”

#### **2/7.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Мөрдөн байцаалт дууссан бол хэргийн материалтай танилцаж, төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлан авах эрхтэй.”

#### **3/11.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг прокурор, өмгөөлөгч хуулбарлан авах эрхтэй.”

#### **4/12.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, хаяг, харилцаа холбооны утасны дугаарыг ашиглан дуудаж, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно.”

#### **5/14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдэж, яллагдагчаар татагдан цагдан хоригдсон бол цагдан хорих хугацааг шинээр тоолно.”

#### **6/14.10 дугаар зүйлийн 14, 15 дахь хэсэг:**

“14.Хоригдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед хорих ялын хугацаа дуусахаар бол энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

15.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийн дагуу хоригдлыг цагдан хорих байранд хүлээн авсан өдрөөс эхлэн цагдан хорих хугацааг тоолно.”

#### **7/14.13 дугаар зүйлийн 13, 14 дэх хэсэг:**

“13.Таслан сэргийлэх арга хэмжээний талаар талуудаас шүүхэд гаргасан санал, хүсэлт, тэдгээртэй холбоотой нотлох баримтыг эрүүгийн хэрэгт хавсаргана.

14.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5 дахь заалтад заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах санал, хүсэлт болон хугацаа сунгасан шүүхийн шийдвэрийг даруй мөрдөгч, прокурорт мэдэгдэж, эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.”

#### **8/15.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Дээд шатны прокурорын газар нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд хянаж шийдвэрлэнэ.”

#### **9/16.3 дугаар зүйлийн 10-12 дахь хэсэг:**

“10.Гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрвэл мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу явуулна.

11.Дүрс харж ярих боломжтой технологи, мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдүүлгийг авч болно. Энэ тохиолдолд өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн оролцоог ханган дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж, хавтаст хэрэгт хавсаргана.

12.Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, түүнээс гэрчийн мэдүүлэг авахыг хориглоно.”



**10/16.14 дүгээр зүйлийн 5-9 дэх хэсэг:**

“5.Эд мөрийн баримтыг бэхжүүлэхдээ тэдгээрийг хэн, хэзээ, ямар эх сурвалжаас хэрхэн олж авсан талаар, түүний онцлог шинж, хэлбэр дүрс, тоо хэмжээ, хадгалсан, шилжүүлсэн, хүлээн авсан шилжилт хөдөлгөөний талаар мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгана.

6.Цахим баримтыг бэхжүүлэхдээ цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээ, хэрэглэсэн техник хэрэгслийг бэхжүүлсэн тэмдэглэл үйлдэж, гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээр давхар баталгаажуулна.

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан ажиллагаанд оролцсон тусгай мэдлэгтэй мөрдөгч, мэргэжилтний хийсэн үйлдэл, үйл ажиллагааны нөхцөл байдал, авсан арга хэмжээ, ажиллагааны үр дүнг тэмдэглэлд бүрэн тусгана.

8.Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцож болно.

9.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална.”

**11/30.14 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн материалыг прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд дээд шатны прокурор энэ хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.”

**12/30.15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэр гаргах хугацааг хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан дээд шатны прокурор 14 хүртэл хоногоор сунгаж болно.”

**13/31.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцах, гарын үсэг зурах, гардан авахаас татгалзсан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй.”





**14/31.14 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт:**

“1.4.гадаад улсад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт хүргүүлсэн бол.”

**15/32.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан тогтоолыг яллагдагчид танилцуулж, хувийг гардуулна.”

**16/32.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлтийг яллагдагчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө.”

**17/34.19 дүгээр зүйлийн 1.9 дэх заалт:**

“1.9.нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүй.”

**18/35.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэрэгт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн хэлэлцүүлэг явуулах дарааллыг тогтоохдоо өөрийнх нь хууль ёсны ашиг, сонирхол хөндөгдөхгүй шүүхийн хэлэлцүүлэг явагдах үед шүүх хуралдааны танхимд байлцахгүй байх талаар оролцогчийн гаргасан хүсэлтийг талуудын саналыг харгалзан шийдвэрлэж болно. Шүүх хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаанд үргэлжлүүлэн оролцох товыг оролцогчид мэдэгдэнэ.”

**19/36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө.”

**20/39.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн гаргасан давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэхэд хамаарахгүй.”



**2 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “1.5 дахь заалт,” гэсний дараа “31.4,” гэж, 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хохилогч,” гэсний дараа “гэрч,” гэж, 10.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “оролцож байгаа” гэсний дараа “хохилогч,” гэж, 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн, 12.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шинжээч,” гэсний дараа “сэжигтэн,” гэж, 14.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “прокурор,” гэсний дараа “яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч,” гэж, 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан,” гэсний дараа “эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдсон, эсхүл гэрчийн мэдүүлэг авах үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/1.4 дүгээр зүйлийн 1.20 дахь заалт:**

“1.20. “талууд” гэж шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцож, санал, хүсэлтийнхээ үндэслэлийг тайлбарлах, танилцуулах оролцогч, эсхүл яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэгчийг;”

**2/5.1 дүгээр зүйлийн 2.4 дэх заалт:**

“2.4. хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг энэ хуульд заасан журмын дагуу мөрдөгч, прокурор, шүүхэд гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох;”

**3/5.1 дүгээр зүйлийн 2.6 дахь заалт:**

“2.6. мөрдөн шалгах ажиллагаа дууссанаар мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны үед хийгдсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон тэмдэглэлтэй хэргийн материалтай танилцах үед төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлан авах, тэмдэглэлд засвар оруулах тухай хүсэлт гаргах;”

**4/5.1 дүгээр зүйлийн 2.13 дахь заалт:**

“2.13. сэжигтнийг баривчлах, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих, бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг

шийдвэрлэхэд оролцох, таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэл, түүний нотлох баримттай танилцах;”

**5/7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлттэй танилцах, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцаж, төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг дууны, дүрсний, дуу-дүрсний болон бусад техник хэрэгсэл ашиглан өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах эрхтэй.”

**6/8.2 дугаар зүйлийн 1.8 дахь заалт:**

“1.8.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцаж, төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй;”

**7/14.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулан тооцох ба энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан цагдан хорих үндсэн хугацаанаас хасаж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно.”

**8/14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийн үндэслэлд хамаарах баримт, мэдээллийг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт тайлбар хийх, холбогдох баримт, мэдээллийг гаргаж өгөх боломжоор хангана. Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.”

**9/16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Шүүх, прокурор, мөрдөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтооход ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай шийдвэр гаргана. Хүсэлтийг хэсэгчлэн хангасан, эсхүл хангахаас татгалзсан үндэслэлийг шийдвэртээ тодорхой тусгана.”



**10/31.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулж, хувийг гардуулан өгнө. Төрийн нууцад хамаарах хэргийн яллагдагчаар татах тогтоолыг яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулахгүйгээр танилцуулна.”

**11/32.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг:**

“2.Мөрдөн шалгах ажиллагаа дууссаныг мэдэгдсэний дараа яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалыг эх хувиар нь танилцуулах ба энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчид хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хавтаст хэргийн материал танилцуулах хугацаа 7 хүртэл хоногт, бусад хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах боломж, нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.”

**12/32.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагаа бүрэн хийгдэж дууссаны дараа мөрдөгч холбогдох саналыг хавтаст хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт шилжүүлнэ.”

**13/32.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийн материалыг ажлын 3 өдрийн дараа харьяалах шүүхэд шилжүүлэх тухай яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.”

**14/32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Өмгөөлөгч хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө энэ хуулийн 32.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан яллагдагчийг шүүхэд шилжүүлэхтэй холбоотой санал, хүсэлтийг бичгээр гаргаж, хэрэгт хавсаргаж болно.”

**15/33.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ. Прокурор, оролцогч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.”

**16/34.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хохирогч бичгээр хүсэлт гаргасан, эсхүл улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулна.”

**17/34.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна. Шүүх хуралдааныг хойшлуулахад хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд энэ хуулийн 33.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтална.”

**4 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.7, 2.8, 2.9 дэх заалтын дугаарыг “2.8, 2.9, 2.10” гэж, мөн зүйлийн 2.10, 2.11, 2.12, 2.13, 2.14, 2.15 дахь заалтын дугаарыг “2.11, 2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16” гэж, 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “шийдвэртэй танилцах” гэснийг “шийдвэртэй танилцах, шийдвэрийн хувийг авах” гэж, 11.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хүсэлт гаргах” гэснийг “хүсэлт гаргах, төрийн нууцад хамаарахаас бусад хэсгийг хуулбарлан авах” гэж, 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “14.9 дүгээр зүйлд” гэж, 14.10 дугаар зүйлийн “5, 6, 7, 8, 9, 10, 11, 12” дахь хэсгийн дугаарыг “6, 7, 8, 9, 10, 11, 12, 13” гэж, 15.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “21” гэснийг “30” гэж, 30.7 дугаар зүйлийн 1.3 дахь заалтын “гэрчээс” гэснийг “гэрч, сэжигтнээс” гэж, 31.2 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнй дараа хийгдэх ажиллагаа” гэснийг “Сэжигтнийг дуудан ирүүлэх ажиллагаа” гэж, 31.3 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах” гэснийг “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах, гардуулан өгөх” гэж, 32.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн “тухайн ажиллагаанд холбогдох оролцогчид танилцуулна” гэснийг “энэ зүйлд заасан журмын дагуу оролцогчид танилцуулна” гэж, 34.12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “үндэслэл болно” гэснийг “үндэслэл болох ба энэ талаарх мэдээллийг харьяалах прокурорын байгууллага, Монголын



Өмгөөлөгчдийн Холбоонд даруй хүргүүлнэ” гэж, 34.19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “1.1-д” гэснийг “1.9-д” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “төлбөрийн чадваргүйн улмаас” гэснийг, 16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар” гэснийг, 32.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийн “өмгөөлөгчийн” гэснийг, 32.9 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “яллах дүгнэлт үйлдэх үед” гэснийг, 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж” гэснийг тус тус хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**



























## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.10. Тулгар төр байгуулагдсаны ой, Их Монгол Улс байгуулагдсаны ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардын хувьсгал, Ардчилсан хувьсгалын ойн баярыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Хуульч Сүхбаатар

2025 оны 07 сарын 03-ны өдөр / 2025 оны 07 сарын 03-ны өдөр /

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Хуульч Сүхбаатар  
2025 оны 07 сарын 03-ны өдөр / 2025 оны 07 сарын 03-ны өдөр /

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Хуульч Сүхбаатар  
2025 оны 07 сарын 03-ны өдөр / 2025 оны 07 сарын 03-ны өдөр /

Хуульч Сүхбаатар  
2025 оны 07 сарын 03-ны өдөр / 2025 оны 07 сарын 03-ны өдөр /

Хуульч Сүхбаатар

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 57

Улаанбаатар  
хот

### **Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хот, суурин газрыг орон сууцжуулахад ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т үүрэг болгосугай:

1/ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор урт хугацаатай, хүүгийн татаастай санхүүгийн зохицуулалтын тогтолцоог бий болгож, холбогдох хууль тогтоомжид тусгах талаар зохих арга хэмжээг авч, хэрэгжилтийг зохион байгуулах;

2/ногоон зээлийн хүүгийн татаасын 80-аас доошгүй хувийг дулаалгын материал, угааргүй халаалтын тоног төхөөрөмжид төвлөрүүлэх зорилгоор агаар орчны бохирдлыг бууруулах дулаалга, ногоон барилга, эрчим хүчний хэмнэлттэй халаалт болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн бүтээгдэхүүний санхүүжилтэд чиглүүлсэн агуулгаар “Ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх гэрээ”-г шинэчлэн боловсруулж, уг гэрээг жил бүрийн эхний улиралд багтаан арилжааны банкнуудтай байгуулж, хэрэгжүүлэх;

3/ногоон зээл, хүүгийн татаасын ил тод байдлыг хангах “Хэмжих-Хянах-Тайлагнах” баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог бий болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар зохих арга хэмжээг авч, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах;

4/утаагүй бүсэд хамаарах дэд төвүүд, агаарын бохирдол өндөртэй болон дахин төлөвлөлтийн бүсийг тогтоож, нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусган, тухайн бүсэд эрчим хүчээр найдвартай хангах төлөвлөлтийг боловсруулж, ипотекийн болон ногоон зээлийн хөнгөлөлт, ногоон зээлийн хүүгийн татаасын бодлогыг чиглүүлэх, энэ талаар олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх;

5/эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын шалгуур /BestGER/-т суурилсан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах,

аудит, хяналт шинжилгээ, баталгаажуулалтын тогтолцоог бий болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

6/хот, суурин газрын гэр хорооллын хэсэгт амины орон сууц барьсан тохиолдолд 50-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэйг нотлох тохирлын болон ногоон барилгын шалгуур /BestGER/ гэрчилгээг тус тус авсныг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг олгох талаар эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах;

7/төрийн өмчит болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийг төлөвлөхдөө ногоон барилгын шалгуур /BestGER/ гэрчилгээний “В” болон түүнээс дээш үнэлгээтэй, 50-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэй байх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

8/төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй, утаагүй технологид үе шаттайгаар шилжүүлэх;

9/монгол гэрийн эрчим хүчний хэмнэлттэй дулаалгын стандартыг шинээр боловсруулж, үйлдвэрлэл, аудит, хяналт шинжилгээ, баталгаажуулалтын тогтолцоог бий болгож, холбогдох хууль тогтоомжид тусгах талаар зохих арга хэмжээг авч, хэрэгжилтийг зохион байгуулах;

10/Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох зээлийн багцын 50-аас доошгүй хувийг ногоон барилга, барилгын материал үйлдвэрлэгч, эрчим хүчний хэмнэлт бий болгох чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч, ногоон барилгын баталгаажуулалт хийх иргэн, аж ахуйн нэгжид олгох ажлыг зохион байгуулах;

11/ногоон барилгын шалгуур /BestGER/ гэрчилгээ, 70-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэйг нотлох тохирлын гэрчилгээтэй дулаалгын ажил гүйцэтгэсэн иргэнд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

12/ногоон барилгын шалгуур /BestGER/ гэрчилгээний “В” болон түүнээс дээш үнэлгээтэй, 70-аас дээш хувийн эрчим хүчний хэмнэлттэйг нотолсон тохирлын гэрчилгээтэй амины орон сууцыг худалдсан тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татварын хувь хэмжээг 1 хувь болгон бууруулах чиглэлээр холбогдох

хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

13/улсын хэмжээнд утааг бууруулах чиглэлээр дулаалгын төлөвлөгөөг боловсруулж, шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусган хэрэгжилтийг зохион байгуулах;

14/агаарын бохирдлыг бууруулах зорилгоор олгож байгаа холбогдох татаасыг дулаалгын бодлогод чиглүүлж, ногоон зээлийн хүүгийн татааст шилжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, зээлийн хүүг 6 хувиас ихгүйгээр тогтоох;

15/монгол гэрийн дулаалгын нийт зардлын тодорхой хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах;

16/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан айл өрхүүд сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэж, орлого олох бололцоог нээж байгаа “10000 нарны дээвэр” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах;

17/эрчим хүчний хэмнэлт, ногоон барилгын хөгжлийг дэмжихтэй уялдуулан холбогдох чиглэлийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургуулийн хичээлийн хөтөлбөрт ногоон барилга, тогтвортой хөгжлийн агуулгыг тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах.

2.Ногоон зээлийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд үүрэг болгосугай:

1/ногоон зээлийн ангилал, шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн тодорхойлж, ногоон санхүүжилтийн тайлагнал, хяналт шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгон ил тод байдлыг сайжруулах;

2/арилжааны банкнуудын ногоон зээлийн тайлан гаргах давтамж, бүрдүүлэлт, мэдээллийн чанар, шалгуурыг шинэчлэн сайжруулах арга хэмжээг авах;

3/ногоон зээлийн хүүгийн татаасын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад валютаар хийгдэх своп хэлцэлд бодлогын дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авах;



4/ногоон барилгын зээлийн эрсдэлийн жинг бууруулах бодлогыг ногоон барилгын шалгуур /BestGER/-т уялдуулан цаашид тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлж, шаардлагатай зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгох;

5/Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд ногоон барилгын шалгуур /BestGER/ үнэлгээний үзүүлэлт, эрчим хүчний хэмнэлтийн бодлоготой уялдуулан, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцанд давуу байдал олгох зохицуулалтыг тусгаж, хэрэгжүүлэх.

3.Энэ тогтоолд заасан арга хэмжээний биелэлтийн тайлан, үр дүнг үнэлсэн дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Бейсен/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**













## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 06 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар  
хот

### **Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан холбогдох аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлах;

2/хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1.1</sup>, 27<sup>1.2</sup> дахь хэсэгт нийцүүлэх зорилгоор судалгаа хийж, холбогдох хуулийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хянан баталгаажуулсан орчуулга, тэдгээрийн эх бичвэрийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 2026 онд багтаан бүрэн эхээр байршуулах;

4/хууль санаачлагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагын албан хаагчдыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэх.

2.Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт даалгасугай:



1/хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох;

2/хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;

3/эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;

4/эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх.

3.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох салбарын хууль тогтоомжийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.1, 27<sup>1</sup>.2 дахь хэсэгт нийцүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслийн судалгаа, саналыг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт даалгасугай.

4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хуульд нийцүүлэн хийж, үнэлгээг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тогтмол байршуулах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод, Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Баасандорж/, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

5.Монгол Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу товьёг хийх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодод даалгасугай.

6.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг нийтийн эрх зүйн этгээдэд зөвлөсүгэй.



7.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

8.Энэ тогтоолыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

### Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан “Оюу толгой” бүлэг ордын талбайн хил заагт орших “Жавхлант”, “Шивээ толгой” ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг ашиглахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэх, тэдгээрийн шаардлагыг хангуулах, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч талтай 2011 онд байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээ /Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон/-ний 11.3(ё)-т зааснаар хөрвүүлэх өдрөөс хойш долоон жил тутамд санхүүжилтийн хүүгийн зохистой хувийг хянан үзэх хугацаа нь 2025 онд болж байгаатай холбогдуулан Оюу толгой төслөөс хүртэх Монголын талын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх”-ээр тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/“Жавхлант” (MV-15225), “Шивээ толгой” (MV-15226) ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг тогтоож, үнэлгээг тодорхойлсон болон холбогдох бусад баримтад үндэслэн төрийн зээмшлийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдуулан хяналт шалгалт хийх;

2/“Оюу толгой” ХХК-ийн Хувь нийлүүлэгчдийн гэрээ /Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон/-ний санхүүжилтийн хүүгийн хувь, түүнийг олон улсын зах зээлийн жишигт нийцүүлэн бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох үр дагаврыг судлан хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах.



3. Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Олонхийг төлөөлөн:**

М.Бадамсүрэн	Улсын Их Хурлын гишүүн
О.Батнайрамдал	Улсын Их Хурлын гишүүн
Б.Бат-Эрдэнэ	Улсын Их Хурлын гишүүн
Б.Баярбаатар	Улсын Их Хурлын гишүүн
Э.Болормаа	Улсын Их Хурлын гишүүн
С.Зулпхар	Улсын Их Хурлын гишүүн

**Цөөнхийг төлөөлөн:**

Ш.Бямбасүрэн	Улсын Их Хурлын гишүүн
П.Ганзориг	Улсын Их Хурлын гишүүн
Б.Жаргалан	Улсын Их Хурлын гишүүн
Д.Пүрэвдаваа	Улсын Их Хурлын гишүүн
Ө.Шижир	Улсын Их Хурлын гишүүн

4. Тусгай шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлж, тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд даалгасугай.

5. Энэ тогтоолыг 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20,089,129.3 сая /хорин их наяд наян есөн тэрбум нэг зуун хорин есөн сая гурван зуун мянга/ төгрөгөөр баталсугай.

2.Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 21,372,400.2 сая /хорин нэгэн их наяд гурван зуун далан хоёр тэрбум дөрвөн зуун сая хоёр зуун мянга/ төгрөгөөр баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

### Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 67

Улаанбаатар  
хот

### **Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн хавтаст хэргийг цахимжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллагуудын цахим мэдээллийн санг нэгтгэн холбох, цахим системийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим хэрэгсэл ашиглаж нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, үнэлэх ажиллагааг боловсронгуй болгох;

3/эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч цахим хавтаст хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах ажиллагааг боловсронгуй болгох;

4/эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж тайлбар, мэдүүлэг өгсөн хэрэгт нь тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болгохгүй байх зохицуулалтыг судлан, олон улсын гэрээнд нийцүүлэн холбогдох хуулийн төслийг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/энэ тогтоолын 1, 2, 3 дахь дэд заалтад заасан үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.АМАРБАЯСГАЛАН**



Монгол Улсын Ерөнхийлөгч /З. Энхбаяр/ 2025 оны 06 дугаар сарын 06 өдөр /2025 оны 06 дугаар сарын 06 өдөр/

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ /З. Энхбаяр/ 2025 оны 06 дугаар сарын 06 өдөр /2025 оны 06 дугаар сарын 06 өдөр/

Урьдчилсан үндэслэл  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ



**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 4.5

**Индекс: 200003**